

# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 56%-ийн саналаар баталсугай.
2. Компани 2018 онд алдагдалтай ажилласан байх ба банкны өмнө хүлээсэн зээлийн гэрээний үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүй талаар хувьцаа эзэмшигчдэд танилцуулсугай..

ХУРЛЫН ДАРГА  Б.НАРАНЗУЛ



# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг чөлөөлж, шинээр сонгох болон  
гишүүдэд цалин олгохгүй тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн 2018.04.30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар томилсон ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь чөлөөлсүгэй.
2. “Хөнгөн бетон” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 2019 оны 4-р сарын 30-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:

а/ ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Тошил овогтой Баярхүү
2. Баярхүү овогтой Наранзул
3. Баярхүү овогтой Наранцацралт
4. Баасанжав овогтой Мөнхцацралт
5. Нэмэхбаатар овогтой Эрдэмбилэг
6. Нэмэхбаатар овогтой Эрдэмбаяр

б/ ТУЗ-ийн хараат бус гишүүд:

7. Бямбасүрэн овогтой Батболд
8. Шаравсамбуу овогтой Энхтөр
9. Доржпүрэв овогтой Энхнаран

3. ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгохгүй байхаар тогтосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НАРАНЗУЛ